

## ТАНИЛЦУУЛГА

2018 оны 04 дүгээр сарын 06

Улаанбаатар хот

Өргөдөл, гомдол шийдвэрлэсэн  
дүнгийн талаар

### **Нэг. Иргэд, байгууллагаас цагдаагийн байгууллага, албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар**

Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсийн албан тушаалтанд 2018 оны 1 дүгээр улиралд иргэд, байгууллагаас 3098 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 537 нэгжээр буюу 21.0 хувиар өсчээ.


Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 9 буюу 0.3 хувь нь санал, 3046 буюу 98.3 хувь нь өргөдөл, 43 буюу 1.4 хувь нь гомдол байна.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл,  
гомдол



Санал, өргөдөл, гомдлыг утгаар нь авч үзвэл: 356 буюу 11.5 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 76 буюу 2.5 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 445 буюу 14.4 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 951 буюу 30.7 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 199 буюу 6.4 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 1071 буюу 34.6 хувь нь бусад өргөдөл гомдол байна.



Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 3008 буюу 97.1 хувийг шийдвэрлэж, 90 буюу 2.9 хувь нь ажиллагаанд байна.



**Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар**

2018 оны 1 дүгээр улиралд Цагдаагийн ерөнхий газрын удирдлагуудад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 225 өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 нэгжээр буюу 5.6 хувиар өсчээ.

Нийт хүлээн авсан өргөдөл, гомдлын 7 буюу 3.1 хувь нь гомдол, 218 буюу 96.9 хувь нь өргөдөл байна.




Иргэд, байгууллагаас цагдаагийн албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлыг үтгээр нь авч үзвэл: 11 буюу 4.9 хувь нь ажилд орох суралцахыг хүссэн, 8 буюу 3.6 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 24 буюу 10.7 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 4 буюу 1.8 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 56 буюу 24.9 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 122 буюу 54.2 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.



**Гурав. Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д ирсэн өргөдөл, гомдол, шүүмжлэл, санал хүсэлтийн талаар**

2018 оны 1 дүгээр улиралд иргэдээс Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 101 санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдөл ирүүлсний 45 буюу 44.6 хувь нь санал хүсэлт, 42 буюу 41.6 хувь нь гомдол, 12 буюу 11.9 хувь нь талархал, 2 буюу 1.9 хувь нь шүүмжлэл байна.




Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдлийн 77 буюу 76.2 хувийг шийдвэрлэж, 24 буюу 23.8 хувь нь ажиллагаанд байна.

Иргэдэд хариу хүргүүлсэн байдлыг чанараар нь авч үзвэл 52 буюу 67.5 хувийг 5 хоногийн дотор, 25 буюу 32.5 хувийг 5-аас дээш хоногт шийдвэрлэжээ.

**Дөрөв. Иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар**

2018 оны 1 дүгээр улиралд иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой 492 өргөдөл, гомдол хүлээн авч шалгасныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26 нэгжээр буюу 5.6 хувиар өсч, 556 алба хаагч холбогдсоны 459 буюу 82.6 хувь нь офицер, 94 буюу 16.9 хувь нь ахлагч, 3 буюу 0.5 хувь нь энгийн алба хаагч байна. Нийт өргөдөл гомдлын 415 буюу 84.3 хувийг шийдвэрлэж, 77 буюу 15.7 хувь нь ажиллагаанд шалгагдаж байна.



Нийт зөрчлийг төрлөөр нь авч үзвэл: 18 буюу 3.7 хувь нь хууль ёс, хүний эрх чөлөөг зөрчсөн, 43 буюу 8.7 хувь нь хэрэг материал дутуу шалгасан, 12 буюу 2.4 хувь

нь хэргийн хугацаа хэтэрсэн, 14 буюу 8.8 хувь нь бусдыг чирэгдүүлж танил тал харсан, 3 буюу 0.6 хувь нь хээл хахууль, шан харамж авсан, 106 буюу 21.5 хувь нь цагдаагийн алба хаагчийн харьцааны соёл, ёс зүй зөрчсөн, 63 буюу 12.8 хувь нь бусдыг зодож эрх чөлөөнд нь халдсан, 89 буюу 18.1 хувь нь ажлын хариуцлага алдсан, 14 буюу 2.8 хувь нь архидан согтуурсан, 3 буюу 0.6 хувь нь өмч хөрөнгө үрэгдүүлсэн, 120 буюу 24.4 хувь нь Эрүүгийн байцаан шийтгэх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль дүрэм зөрчсөн, 7 буюу 1.4 хувь нь бусад зөрчлүүд эзэлж байна.

### Зөрчлийн төрөл



Сахилгын арга хэмжээ авагдсан байдлыг авч үзвэл: Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдолд шалгалтын ажиллагаа явуулж, 13 буюу 2.6 хувийг эрүүгийн хэрэг үүсгэхээр шилжүүлж, 125 буюу 25.4 хувийг сахилгын шийтгэл оногдуулж, 310 буюу 63 хувийг цагдаагийн алба хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй, 26 буюу 5.3 хувийг алба хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдсон боловч хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн үндэслэлээр тус тус шийдвэрлэсэн байна.

## ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС